



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/181

Булган

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд тусгагдсан Могод сумын Эрүүл мэндийн төвийн барилгын засварын ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн хурлын зөвлөмжийн дагуу “Баян өндөр булаг” ХХК-ийг сонгож 264 305 755 /Хоёр зуун жаран дөрвөн сая гурван зуун таван мянга долоон зуун тавин тав/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Ү.Бямбасүрэн/-т олгосугай


2. Дээрх ажлын гүйцэтгэгчтэй холбогдох хууль, журмын дагуу гэрээг байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж, хүлээн авахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Д.Буманбаяр/, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Ү.Бямбасүрэн/-т даалгасугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Баян өндөр булаг” ХХК /Л.Батноров/-д үүрэг болгосугай.

4. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль, журмын гэрээний дагуу Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Д.Батцогт/-т зөвшөөрсүгэй.

5. Хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж, хяналт тавин ажиллахыг холбогдох байгууллагын дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

Аймгийн Засаг даргын 2019 оны сарын
өдрийн дүгээр захирамжийн 1-р хавсралт

№	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн /хувь/	Хариуцах албан тушаалтан
1	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	2,341,550	Ү.Бямбасүрэн
2	Магадлашгүй ажил	4,683,101	Ү.Бямбасүрэн
3	Техник хяналтын зардал	4 683.101	Ү.Бямбасүрэн
4	Орон нутгаас авах ажиллах хүчний тоо	16 хүн	Н.Батжаргал
5	Алданги	Хоногт гэрээний үнийн дүнгийн 0.05 хувь	Д.Батцогт
6.	Ажил гүйцэтгэх хугацаа	Гэрээ байгуулснаас хойш 60 хоног	Ү.Бямбасүрэн